



# “ДЭЭС- НИЙ ЭРЧ ”

Хэнтий аймгийн  
ХЭРЛЭН сумын  
Тахилгат тосгон  
Шархад БАХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 ОНЫ 11САРЫН 11 ӨДӨР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨГ: 1,523,000

## Төсөл хэрэгжсэн газар

Төсөл хэрэгжсэн: Хэнтий аймаг,  
Хэрлэн сумын Тахилгат томгон  
Шархад БАХ –ын нутагт

## Төслийн зорилго

Төслийн зорилго: Малчин  
эмэгтэйчүүд өрхийн орлогоо  
нэмэгдүүлж, уламжлалт өрхийн  
үйлдвэрлэлийг хөгжүүлэх

## Төслийн зорилтууд

Төслийн зорилтууд:


- Адууны дэл сүүл,  
тэмээний ноосыг авч  
бэлтгэх
- Дээс томох уламжлалт  
арга ухааныг суралцах
- БАХ-ын эмэгтэйчүүдийг  
сургах

Төслийн хүрээнд: БАХ-ын нийт  
40 өрхийн 18-н эмэгтэйчүүд  
хамтран ажиллаж дээсний  
эрчийг сурталчилан  
танилцуулснаар гэрийн бүслүүр  
уяаг томох арга аргачлалд  
суралцлаа.

## Төслийн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Санхүүжилт, төгрөг
Төслөөс	1,000,000
Малчид	523,000
<b>Нийт</b>	<b>1,523,000</b>

Төслийн санхүүжилтийн эргэн  
төлөлт: 1,000,000 төгрөг



Дээс хошлон хийх гар машин

## Үйл ажиллагаа:

Төслийн үйл ажиллагаа малчин эмэгтэйчүүдийг уламжлалт өрхийн үйлдвэрлэлээ хөгжүүлэхэд сургаж малын гаралтай бүтээгдэхүүнээ хаягдалгүй ашиглаж өрхийн орлогоо нэмэгдүүлэх үйл



## Хялгасан бүслүүр

**Сургамж:** Төслийн үр дүнг  
тооцох хугацаа жаахан  
богино байсан. Малчдын  
урьд нь бэлтгэсэн байсан дэл  
сүүл дээр ажилласан нь  
хүрэлцээ муутай болж өрх  
бүр хийх боломжийг  
хойшлуулсан ч энэ нь  
төслийн үргэлжлэх хугацааг  
уртасгаж өгсөн давуу тал  
болон харагдаж байгаа. Мөн  
тэмээний ноосон утас олдоц  
муутай байна

ажиллагаа явуулна. Тус БАХ-ын нийт 40-н өрхөөс ойролцоо нутагладаг 18-н өрхийн малчин эмэгтэйчүүд хамрагдаж адууны дэл сүүлээ авсан байсан бөгөөд төслийн дэмжлэгийн үр дүнд ахмад малчин эмэгтэйд очиж дээс томох уламжлалт арга ухаанаас суралцлаа.

### Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Төслийн санхүүжилтийг юунд зарцуулсан талаар доорх хүснэгтэнд мэдээлэл оруулна

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Адууны дэл сүүл тэмээний ноос авах	кг	30	8000	240000
2	Шатахууны зардал	л	100	1580	158000
3	Гараар сэмлэх машин	багц	1	1320000	1125000
	Нийт				<b>1523000</b>

### Борлуулалт, үйлчилгээний орлого

Төсөл хэрэгжсэнээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ, тэдгээрээс олсон орлогын талаар энэ хүснэгтэнд мэдээлэл оруулна.

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Гэрийн бүслүүр	Метр/20м /	18	80000	1440000
2	Өрхний 4-н оосор зээг хийх утас	багц	5	60000	300000
3	Тугалын ногт уяа	метр	6	30000	180000
4	Томсон дээс	метр	20	4000	80000
	<b>Нийт</b>				<b>2 000 000</b>

### ТӨСЛИЙН ҮР ДҮН

Төсөл хэрэгжсэнээр хялгас томон урлаж оёсон бүтээлүүдийг судлан үзэж монгол гэрийн бүслүүр, хялгасан дээс, зэл, чагт, үнээний тушаа, унаган ногт зэрэг олон төрөл байдаг тухай мэдлэгийг олж авсан Унгас ноос, дэл хялгасаар томон урлал болгон хөгжүүлэх боломж байх бөгөөд Монгол билэгдэлт үг бүтээн урлах боломжтой юм. Малын унгас ноос, дэл хялгасаар мал аж ахуйн амьдралынхаа эдлэл хэрэглэлийг хийж сурах, хойч үеийнхэндээ таниулан сурталчилан үлдээх нь хамгийн чухал юм

Таван хошуу малынхаа ашиг шимийг бүрэн боловсруулах хүн өдрөөс өдөрт цөөрч байгаа энэ үед уламжлалт соёл арга ухааныг малчин эмэгтэйчүүд өөрсдөө хийж үлгэрлэх нь түүхэн ач холбогдолтой юм. Уламжлалт аргаар хийсэн бүслүүр уяа нь удаан эдэлгээтэй органик хэрэглээ байдаг .

Дээс томох нь монгол хэл бичигт “ноос үсийг салгаж самчин түүдэг хийсний дараа баруун солгой эрч оруулан нийтгэх” гэсэн утга илэрхийлдэг бөгөөд орчин үед энэхүү гар ажиллагааг хялбаршуулсан жижиг гар машинуудыг зохион бүтээсэн байгаа нь талархууштай юм.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат багийн Шархад БАХ-н гишүүн Дэжидмаа болон 18-н өрхийн эмэгтэйчүүд төслийн үр шимийг хүоцртэв. Тэдний үр дүнд үндэслэн тус БАХ-ийн эмэгтэйчүүдийн дунд дээс томох уралдаан зарлах зорилготой ажиллаж байна.

## ТӨСЛИЙН ЗОРИУЛАЛТ

Төслийн зориулалт, зарцуулалт өөрчлөгдсөн бол учир шалтгааныг тодорхой бичиж ирүүлнэ.

- Төслийн зориулалт, зарцуулалт өөрчлөгдөөгүй болно.